БАГШ НАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ-ОНОЛ ПРАКТИКИЙН XII БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

СЭДЭВ	“СУРГАЛТЫН ИНТЕГРАЦИ БА AI ХЭРЭГСЛҮҮД”	
ХУРЛЫН ТОВ	Хэзээ: 2025.10.04, 09:00-16:30 Хаана: Говь-Алтай аймаг, Алтай хот, Ерөнхий Боловсролын 1-р сургууль	
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулиас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг **“Багш нарын эрдэм шинжилгээ-онол практикийн XII бага хурал”** нь Говь-Алтай аймгийн Алтай хотод зохион байгуулагдана. Тус хурлын зорилго нь инженер технологийн чиглэлээр сургалт явуулдаг их, дээд сургууль, ЕБС-ийн багш, судлаачдын дунд харилцан туршлага, мэдлэг хуваалцах, байгалийн ухааны болон гадаад хэлний сургалтад тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх боломж, сургалтын интеграци ба сургалтад хэрэглэгдэж буй AI хэрэгслүүдийг хэрхэн ашиглах, сургалтын шинэ арга зүйн талаар санал бодлоо солилцоход оршино.	
ХАМРАХ ХҮРЭЭ	Баруун болон төвийн бүсийн аймгуудын Ерөнхий Боловсролын сургууль болон инженер технологийн их дээд сургуулийн багш, судлаачид.	
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	**Хурлын бүтэц:** Илтгэл, хэлэлцүүлэг **“Сургалтын интеграци ба AI хэрэгслүүд”** сэдвийн хүрээнд танхимаар илтгэл хэлэлцүүлэгдэх бөгөөд энэхүү хурал нь хоёр хэсгээс бүрдэнэ. Үдээс өмнө нэгдсэн хуралдаан, үдээс хойш гадаад хэл болон байгалийн ухааны хичээл хоорондын уялдаа холбоог сайжруулах сургалтад AI хэрэглэгдэхүүнийг хэрхэн ашиглах талаар хэлэлцүүлэг өрнүүлэн туршлага солилцох зорилготой салбар хуралдаан хэлбэрээр зохиогдоно. Илтгэгчид илтгэлийн хураангуйг доорх бүтцийн дагуу бэлтгэж ирүүлнэ. - *Өгүүллийн нэр:* “.....” - *Хураангуй:* А4-ийн 1 нүүрэнд багтсан байх - *Түлхүүр үг:* Өгүүлэлд 3-4 түлхүүр үг хэрэглэх ба нэр үг ганц тоон дээр бичнэ. - *Ашигласан материал:* Цагаан толгойн үсгийн дарааллаар - *Өгүүллийн төгсгөлд:* Илтгэгч болон багийн товч танилцуулга ***Доорх холбоосуудаар орж загвар татан, хуралд бүртгүүлнэ үү.*** *Хураангуй бичих загвар татах*. *Бага хурлын бүртгэл*	
ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА	“Хан Алтай Ресурс” ХХК	
ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ	Говь-Алтай аймгийн Боловсролын газар; Говь-Алтай аймаг, Алтай хот, Ерөнхий Боловсролын 1-р сургууль;	
ХОЛБОО БАРИХ	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2-р хороо, МГТИС-ийн хотхон, Холбоо барих: 96069601	Имэйл хаяг: teachersymposium@gmit.edu.mn Цахим хуудас: www.gmit.edu.mn Фейсбүүк: www.facebook.com/gmit.edu
БҮРТГЭЛ	Илтгэгчдийн тоо хязгаартай тул **2025 оны 9 дүгээр сарын 29-ны 13:00цаг** хүртэл teachersymposium@gmit.edu.mn хаягаар илтгэлийн хураангуй болон илтгэлээ илгээнэ үү.	